

БУРХАНЫ ШАШНЫ СҮМ ХИЙДИЙН ЭРХЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ЭХ СУРВАЛЖИЙН ТУХАЙ

Б. Цэвээндорж - МУИС. НШУС. Шашин Судлалын Тэнхим, магистрант

Түлхүүр үг: Бурханы шашин, сүм хийд, дүрэм тогтоол, жаяг, Далай лам, Ламын гэгэээн

Товч утга: Бурханы шашны сүм хийд нь өдөр тутмын үйл ажиллагааг тусгай дэг журмын дагуу зохион байгуулдаг уламжлалтай. Сүм хийдэд дэг журмыг тогтоох гол үүргийг тусгайлан зохиосон жаяг хэмээх бичмэл дүрэм тогтоол дээр суурилдаг. Тиймээс эл өгүүллээрээ сүм хийдийн дотоод дүрэм болох жаяг нь сүм хийдийн эрхзүйн гол эх сурвалж болох бөгөөд шашны эрхзүйн хүрээнд сүм хийдийн эрхзүй гэсэн салбар судлагдахуун байж болох тухай судалгаа шинжилгээний хүрээнд оруулах оролдлогыг хийж байгаа болно.

Өнөө үед яригдаж буй шашны эрхзүй гэсэн сэдвийн хүрээнд “төр сүм хийдийн харилцаа” хэмээх ойлголтоор сүм хийдийн гадаад харилцаа буюу нийгэм, төртэй харилцах эрх үүргийг голчлон ярьж байна. Гэтэл шашин гэдэг бол зөвхөн гадаад харилцаагаар зохицуулагдах буюу төрөөс гаргаж буй хууль тогтоомжийн дагуу л үйл ажиллагаа явуулаад зогсохгүй тухайн сүм хийдийн үйл ажиллагаа нь бусад үйлчилгээний албан байгууллагуудтай ижилхэн л бусдад үйлчлэх, бусадтай харилцах үүргийг хүлээдэг. Тиймээс энд дотоод зохион байгуулалтын асуудлаас эхлээд харилцааны олон хэлбэрүүд үүснэ. Энэ бүхнийг зохицуулахдаа хүмүүсийн харилцаанд байдаг бие биесээ хүндлэх бичигдээгүй хуулийн дагуу зохицуулахаас гадна хийдийн дотоод дүрэм журмыг тогтоосон бичмэл хууль байна. Үүнийг бид “жаяг” хэмээн нэрлэдэг.

Энэхүү ойлголт нь нэр томъёоны хувьд Төвд үг бөгөөд монголоор “цааз тогтоосон үсэг” гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд сүм хийдийн дотоод үйл ажиллагааг зохицуулах зориулалт бүхий бичмэл дүрэм журмын эмхтгэл гэж үзэж болох юм.

Жаягийн үүсэл гарал нь цаг хугацааны хувьд нэн эрт үеэс буюу эртний энэтхэгт бурханы шашин дэлгэрсэн МЭӨ V-VI зууны үеэс эхлэлтэй гэж үзэж болох юм. Бурхан багш өөрийн номлол сургаалаа айлдаж, дагагч шавь нартай болсноор бурханы шашинтан хүн ямар байвал зохистойг өдөр тутмын амьдралаас нь эхлээд өмсөж зүүх, биеэ хэрхэн авч явах зэргийг хуврагийн чуулганаар хэлэлцэн тогтдог байсан түүхтэй. Тухайлбал, Нэгэн залуу дияанч Пуккусати Бурхан багшаас сахил хүртээж, хуврагийн чуулганд багтааж аваач хэмээн хүсэлт тавихад түүнд бадар аяга орхимж хувцас бэлэн байгаа эсэхийг асуугаад Бурхан багш айлдахдаа: “Түүнчлэн ирэгсэд бадар аяга, орхимж хувцасгүй хүнд сахил хүртээдэггүй юм гэжээ”.¹⁴⁶ Тиймээс энэ үеэс жаягийн анхны хэлбэр үүссэн бөгөөд бичмэл хэлбэр гэвэл винайн аймгийн судар

- номонд лам нарын сахил санваарын асуудал зэрэгт тусгагдаж үлдсэн байж

¹⁴⁶ Валпола Рахула. Будда чухам юу сургасан нь. УБ., 2007, 7 дахь тал

болох юм. Винайн аймгийн сударт бурханы шашны лам хүний сахих сахилын нэр төрөл, тоо хэмжээ зэргийн тухай өгүүлсэн байдаг гэдгийг олонтоо сонссон билээ. Харин сүм хийдийн дэг жаягийн тухай "... Буддагийн сахил буюу сахилга батын талаарх зөвлөмж сүм хийдийн үйл ажиллагааны баримтлах үндсэн дэг жаягийн заалтыг Винайн сударт нэг бүрчлэн заасан бий"¹⁴⁷ гэжээ.

Мөн Бурхан багш: "Ананд аа Сангха/хуврагийн чуулган/ хүсэх аваас намайг өнгөрсний дараа сахилын бага сага журмуудыг өөрчилж, халж болох юм"¹⁴⁸ хэмээснээс үзэхэд Бурхан багшийн үеэс л дүрэм журмыг хэлэлцэн батладаг байжээ гэдгийн нотолгоо юм. Бурхан багшийн сургаал номлолын талаар өгүүлсэн зохиол бүтээлээс ажиглахад Энэтхэгт дэлгэрсэн бурханы шашны жаяг нь ерөнхийдөө лам хуврага хийгээд сүсэгтэн хүний хувьд яригдаж байсан гэж үзэж болохоор байна.

Ийнхүү эртний энэтхэг орноо дэлгэрсэн бурханы шашны нөлөө ертөнцийн зүг бүхнээ тархан дэлгэрч, олон ч улс оронд нөлөөлж, нийгмийн болоод ард олны амьдралын салшгүй хэсэг болтлоо хөгжсөн орнуудын нэг нь Төвд орон билээ. Төвд оронд дэлгэрэхдээ ч бурханы шашны уламжлалын салшгүй хэсэг нь жаяг бичиг байсан нь тодорхой.

Төвдөд бурханы шашин дэлгэрэх явцад сүм хийд олноор байгуулагдаж тэдгээрийг дагасан буддын мэдлэг ухааныг судлан сонирхогч лам хуврагуудад зориулан сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилго бүхий дацан сургуулиуд байгуулагдаж байжээ. Энэхүү дацан сургуулиуд болон сүм хийд бүр өөр өөрийн онцлогийг тусгасан дүрэм журмыг баримталж байжээ.

Үүнийг гэрчлэх мэдээ баримт гэвэл нэгдүгээрт, Монгол лам нарын бичиж туурвисан жаяг бичгүүд бол өнөө хүртэл уламжлагдан ирсэн байдаг. Тэрхүү жаяг бичгүүдийг Төвдийн томоохон хийдүүдийн баримталдаг жаягийг дагуулж зохиосон тухайгаа дурдсан байдаг. Энэхүү монгол сүм хийдийн жаягийн талаар доор дэлгэрэнгүй дурдах болно. Хоёрдугаарт, 1992 онд Дээрхийн гэгээн XIV Далай лам монгол орны хүрээ хийдийн үйл ажиллагааг хөтлөн явуулахад зориулан "Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой" хэмээх нэгэн жаягийг айлджээ. Тиймээс жаягийг сүм хийдийн дотоод үйл ажиллагаанд зориулан бичиж байсан уламжлал нь Төвдөөс эх үндэсээ авсан гэдэг нь энэ мэт олон баримтаас харагддаг.

Монгол орноо бурханы шашин хүчтэй дэлгэрсэн үе болох XVI зууны хоёрдугаар хагасаас эхлэн монгол эрдэмтэн мэргэд буддын мэдлэг ухааны өндөр боловсролыг эзэмшихийн зэрэгцээ сүм хийдийг үүсгэн байгуулах ажил маш далайцтай өрнөсөн. Тиймээс энэ үеэс эхлэн төвдөд боловсрол эзэмшсэн лам хуврагууд монгол хүрээ хийдийн онцлогийг харгалзан үзсэн, тухайн үеийнхээ нийгмийн амьдралд зохицсон жаяг бичгүүдийг туурвиж байжээ. Монгол лам нарын зохиол бүтээлийн гарчгаас харахад өөр өөрсдийн үүсгэн байгуулсан хүрээ хийддээ зориулсан жаягуудыг туурвисан байдаг. Өндөр гэгээн

¹⁴⁷ XIV Далай лам. Төвдийн бүддийн ертөнц. УБ., 19 дэх тал

¹⁴⁸ Мөн тэнд, 138 дахь тал

Занабазар, Цахар гэвш, Агваанхайдав, Зава Дамдин гавж гэх зэрэг олон эрдэмтэн мэргэд жаяг зохиож байсан мэдээ байна. Тухайлбал С.Пүрэвжав гуай “Шарын шашны хураангуй түүх” хэмээх номондоо “Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандид хутагтийн (ламын гэгээн) хүрээний болон халхын түшээт хан аймгийн түшээт засаг гүн Доржболдын зохиосон жаяг зэрэг дотоод дүрмүүдэд...”¹⁴⁹ гэх мэт жаягуудын тухай дурдсан байна.

Өнөөгийн судалгаанд жаягийн тухай мэдээлэл төдий л байгаа учраас энэ удаад бүтэц агуулгын талаас болон жаяг нь сүм хийдийн эрхзүйн хэм эхмжээг тогтоох баримт бичиг болох талаас нь товчхон ч гэсэн өөрт байгаа материал дээрээ тулгуурлан тодорхойлохыг зорилоо.

Жаягийн бүтэц агуулгын хувьд Далай ламын Монгол орны хүрээ хийдэд зориулсан жаягийн дагуу тодорхойлох нь зохистой байх. Яагаад гэвэл энэ жаяг нь нийт хүрээ хийдийн хэмжээнд авч үзэх асуудлуудыг багтааснаас гадна цаг хугацааны хувьд нилээд сүүлийн үеийн нийгмийн өөрчлөлттэй уялдсанаараа уламжлал шинэчлэлийг хослуулсан гэж үзэж болохоор байгаа нь ерөнхий бүтэц гаргахад тохиромжтой гэж үзэж байна. Энэ нь агуулгын хувьд:

Нэгдүгээрт, “Тойн хуврагуудын авал орхилд орох ёс” хэмээх энэхүү хэсэгт лам болох хүний нас болоод сэтгэлзүйн бэлтгэл зэргийг тодорхойлсон. Тухайлбал “Тэр нь ч анхлан лам болоод хуврагийн аймагт ороход орогч шүтээн бодгал нь жаяг дэглэмийг үүрч үл чадах хэтэрхий хөгшин, эсвэл хэтэрхий нялх биш байна”¹⁵⁰ хэмээсэн. Энэ нь үүрэг хариуцлагаас гадна бурханы шашны лам хуврагуудад сахил хүртээхдээ ялангуяа гэгцэл, гэлэнгийн сахилыг хүртээхдээ 25 наснаас хойш хүртээх нь зохистой гэж үздэгтэй холбоотой байж болох юм. Насанд хүрсэн хүн ухаан бодол нь төлөвшөөд лам хуврага болох замдаа тууштай орох сэтгэлзүйн бэлтгэлтэй болохоос гадна эрхзүйн талаасаа бие даан шийдвэр гаргах чадвартай, аливаа үүрэг хариуцлагыг хүлээж, түүнийгээ ухамсарлах, гэм алдал хийсэн үед шийтгэл хүлээх эрхзүйн бүрэн чадамжтай байх шаардлагын үндэс байж болох юм.

Мөн санваар хүртэхэд хамба албан тушаалтнууд лам болох хүнийг сайтар шинжиж санваар хүртэх зөвшөөрөл олгодог бөгөөд өөрийн багшийг сонгон шүтэх эрхийг олгож, багш түүнд эхний ээлжинд зааж сургах зүйлсийг хүртэл тодорхойлон заасан байна. Хуврагуудад эхлээд санваарын дэг жаяг, винайн явдал ёсыг сайтар таниулах үйл ажиллагааг явуулах нь зүйтэй гэжээ.

Үүнээс гадна нисваанис үүсэх нөхцөл бүрдэхээр үйл ажиллагаа буюу “...согтууруулах ундааны төрөл зүйл уух, жин дэнсээр мэхлэх хориотой наймаа эрхлэх зэргээр улсын татвараас хулгайлах хулгайн төрөл зүйл, сахил санваарт нөхөргүйгээр садан бус эмэгтэйтэй нэг гэр оронд нөхөрлөн үйлдэх...”¹⁵¹ гэх мэт өдөр тутмын нийгмийн амьдралын муу муухай үйлээс хол байх тухай заасан.

¹⁴⁹ Пүрэвжав, С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978, 267 дахь тал

¹⁵⁰ Далай лам Данзанжамц. “Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой”. УБ., 1992

¹⁵¹ Далай лам Данзанжамц. “Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой”. УБ., 1992

Ингэснээрээ лам хуврагууд элдэв гэмт хэрэгт холбогдохгүй, нийгэмд лам хуврагуудын нэр хүнд, байр суурийг хамгаалах үүрэгтэй.

Лам хуврага хүний хувцас хунарын зүй зохицол, хэрхэн яаж өмсөх, биеэ авч явах байдал зэргийг дараах байдлаар тусгасан байна. "Номт гурван хувцас зэргийг хэтэрхий навсархай муу эс бөгөөс хэтэрхий ганган хоёр хязгаарт үл унаган хуврагийн амьжиргааны хэрэгсэл таарсан хэмжээ төгс хадгалж үйлдэгтүн. Үс сахалыг цаг цагт нь хусаж үйлдэгтүн. Таншинг нэн тогдойлгох эсвэл нэн унжуулах бус дүгрэглэн тэгшид ороон үйлдэгтүн"¹⁵² гэх мэтчлэн олон зүйлийг дурдсан байна.

Харин дээр өгүүлсэн хориглосон зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд тохирох шийтгэлтийг хүлээлгэх бөгөөд гэм алдал хийсэн лам хуврага өөрийн гэм буруугаа хүлээж, өөрт тохирох шийтгэлийг хүлээн авах ёстой. Шийтгэлийн арга хэмжээ нь бол тухайн гэмт үйлдлээс шалтгаалаад өөр өөр боловч хийдээс хөөх хүртэл шийтгэл оногдуулж болох нь жаягийн хэсгээс харагдаж байна. Жишээ нь: "Дөрвөн ялагдал гаргасан, бусдад хутга мэс хэрэглэсэн, Хамба, Гэсгүй зэрэг албан тушаалтануудад гарын хариу /зодуурын хариу/ барьсан, өмөг хүч /олны хүч/ албан тушаал суудлын хүчээр уршиг таригч муучилыг нүүр тал харалгүй /зэрэг дэвээр зусардалгүй/ бүгд бээр үүргийг аван /зүтгэл гаргаж/ орноос /хийдээс/ хөөгтүн"¹⁵³ хэмээн шийтгэл хүлээлгэх тухай дурджээ. Шийтгэл хүлээлгэх, болон аливаа хуврагийн үйлийг шүүхдээ ихэс дээдэс, хэргэм зэрэгтэн нар нь танил тал, садан төрөл гэж үзэлгүй үнэн зөвөөр шүүх ёстой гэдгийг маш тодорхой зааж өгчээ. Тиймээс энэхүү хэсэг нь бол нийгмийн тодорхой нэгэн салбарын объектыг зохицуулах эрхзүйн хэм хэмжээний акт болох нь зайлшгүй юм. Энэхүү эрхзүйн баримт болох жаяг нь үйлчлэх цаг хугацааны хувьд тохиромжтой, өөрийн гэсэн онцлог нөхцөл бүрдсэн орон зайтай, хэрэгжүүлэгч субъекттай учраас сүм хийдийн дотор эрхзүйн асуудал яригдах ёстой гэдгийг харуулсан нотолгооны нэгээхэн хэсэг юм.

Хоёрдугаарт, "Хүслийг багасган болой мэдлийг шүтэх" хэмээх хэсгийн ерөнхий агуулгын хувьд лам хуврага болох гэж байга болон болсон хүний ахуй амьдралдаа чанд баримтлах зүйлсийг заасан байна. Үүнд "Өглөгийн эзний сайн муу, өглөги йн их багыг үргэлж ил тодорхой хэлэлцэх, нутгийн өглөгийн эзэд зэргээс өргөл хандив гуйх үед хэтэрхий зовж зүдсэн байдал үзүүлэх, өглөгийн их багад туних зэрэг бусдын сүжгийг эвдэх уг шалтгаан болох ба өөрийн хувиас хэтэрсэн аяга цай төдийд ч горилох тэргүүтэй эд таваар хураан сахихаар цагийг нөгцөөхийг хэзээ ч бүү үйлдэгтүн"¹⁵⁴ хэмээжээ. Хуврага хүний амьдрал энгийн гэргийтэн хүний амьдралаас ялгарах бөгөөд шунал хүслээ хязгаарлаж, өөрийн хэрэглээнээс хэтийдсэн зүйлийг хүсэхгүй, наймаа арилжаа хийх зэрэг буруу амжиргааг бүтээх үйлд орохгүй байх нь зохистойг дурджээ.

¹⁵² Мөн тэнд.

¹⁵³ Мөн тэнд.

¹⁵⁴ Далай лам Данзанжамц. "Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой". УБ., 1992, 37 дахь тал

Гуравдугаарт, "Хуралд хурах, суудал барих ёс" үүнд сүм хийдэд ирж буй сүсэгтэнгүүд нь ариун дагшин буяны орон гэж бодож ирдэг тиймээс лам хуврагууд юун түрүүнд хийдийн гадаад дотоод орчныг цэвэрлэх, орчиндоо цэвэр байх, хурлаас хоцролгүй ирж, баруун зүүн мөрийг тэгшлэн суух ёстой. Мөн лам хүний өдөр тутамдаа биеэ авч явах соёлын асуудлыг хөндөж "Хөмхий зуух, ташаа тулах, ийш тийш харах, багана туурга налах, дэмий чалчин ярих, бусад руу ирмэх, уруул амаа хөдөлгөх, унтах, гар хуруугаараа оролдон тоглох... суудлын бүрээс жавдан зэрэгт хайр гамгүй хандах, мөрний хооронд цай асгах, хог хаях, идээ ундааны цагт идээг сайтар эс авах, үлээн тамшаалах, шал шал хийн идэх, цайлах үед нус цэрээ ил хаях зэргийг бүү үйлдэгтүн"¹⁵⁵ хэмээн лам хүн сүсэгтэн олны шүтээн үлгэр дуурайл болох хүний хувьд цаг үргэлж соёлтой боловсон байх талын үүргүүдийг дурджээ.

Мөн үүнээс гадна суудал барих ёс болон элдэв хүндлэл үзүүлэхдээ санваарын хуучин шинэ, албан тушаалтан, санваартан зэрэгтэн нараа өөрөөс дээш залан суулгах, малгайгаа аван орхимжоо буулган хүндэтгэл үзүүлэх ёстой гэх мэт хүндэтгэлийн нарийн дэг жаягийг тогтоосон байна. Энэхүү хүндэтгэлийн хэлбэр бол өнөөгийн манай сүм хийдүүд ч баримталдаг нь хааяа нэг ороход ажиглагддаг.

Дөрөвдүгээрт, "Сонсохыг хичээхэд ямар мэт орох ёс" буюу ном хэрхэн үзэх тухайд сүм хийд нь уламжлалт үйл ажиллагаа явуулахын хамтаар нийгмийн өөрчлөлт шинэчлэл, чиг хандлагад нийцүүлэн аливаа үйл ажиллагаагаа хөтлөн явуулах хэрэгтэй. Ингэхийн тулд зөвхөн уламжлалаа таслахгүйн төлөө л хичээх биш бурханы номлолын мөн чанарыг ойлгож ухаарсны үндсэн дээр өнөөгийн нөхцөл байдалтай нь уялдуулаад эш онолыг хослуулан авч үзэх нь чухал.

Үүнээс гадна лам хуврагуудын үзэх судлах номын дэс дарааг дурдаад сургалтын үеэр амралт чөлөө цагаа хэрхэн өнгөрөөх тухай хүртэл нарийвчлан заажээ. Тухайлбал, "... хэрэв тэгэх аваас тарний гүнзгий мөрийн анисыг онон мэдэхэд дэгжлэг гарах тул эхлэн чойрын ухаанд суралцагтун. Түүнд судлан хичээхийн цар лугаа тааруулан тарний сургуульд орох нь машид их анистай. Хуралд бүтээл тахил тэргүүтнийг цүглэх үед эхнээсээ чога бүгдийг цээжээр уншиж эс чадавч судраар уншин аажмаар цээжлэх арганд шамдах ба гол нь уншиж буй хурлынхаа утгыг ухаарч мэдэхийн үүднээс үгсийн таяганд тулан утгыг шинжлэн бясалган үйлдэх хийгээд судар тарнийн их гол номуудыг сонсох, санахын хос жигүүрээр дотоод ухаанд боловсорч үйлдэгтүн"¹⁵⁶ хэмээжээ. Хуврагуудыг орчин үеийн нийгмийн хөгжилтэй зэрэгцэн боловсрох нь чухал хэмээн бага насны хуврагуудад өнөө үед заавал эзэмших ёстой хичээлүүдийг заадаг бага дунд сургуулийг сүм хийдийн дэргэд байгуулах хэрэгтэй гэх зэргээр лам хуврагууд боловсролын түвшинд анхаарлаа хандуулсан байна. Энэхүү

¹⁵⁵ Мөн тэнд, 38 дахь тал

¹⁵⁶ Далай лам Данзанжамц. "Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой". УБ., 1992, 39-40 дэх тал

заалтын биелэл нь эдүгээ Гандантэгчэнлин хийдийн дэргэдэх Шашны боловсролтой 112 дугаар дунд сургууль байх гэж бодож байна.

Тавдугаарт, “Шалгалт шүүлэг авах ёс” үүнд лам хуврагийн боловсрол эзэмших сургууль дацангуудын шалгалтын үйл ажиллагааны зохион байгуулалт, шалгалтын хэлбэр, шалгалтын үр дүнг хэрхэн үнэлэх тухай маш дэлгэрэнгүй дурджээ. Тухайлбал “Хуврагийн сургуульд голлон цээжлэн давтах, унших бичих, хэл шинжлэлийн ухааны шалгалт авна. Эдгээрийн завсар нэгэн жилд цам бүжиг, бурханы тиг, ая дан зэргийн шалгалтыг авна. Судар тарнийн дацан хийдүүдэд голлон их шүн судруудыг цээжлүүлэх, дагсал хаях шалгалтыг авч үйлд. Энэтхэгийн мэргэд, Богд лам, түүний их шавь нарын номуудыг цээжээр уншиж чадаж байгаа урамшил шагнал олгон байр эзлүүлэх хэрэгтэй. Шалгалт авахдаа аргацаан өнгөрөөх төдий сул зөөлөн бус, чанга авах ёстой”¹⁵⁷ хэмээснээс шалгалтын дүрмийг ч тусгайлан заасан нь харагддаг.

Зургаадугаарт, “Бясалгал бүтээл хийх ёс” хэмээх хэсэгт бясалгал бүтээл хийх гэж хичээж буй хуврагуудад хийд орноос орон байр, зохистой нөхцлийг хангаж өгөх, бясалгагчийн судлах ном хийгээд зам мөрийг заасан байна. Үүнд, “Бясалгаачид бясалгалын газарт бясалган суусан ч олз хүндлэл, яруу алдар ямагтыг сэтгэх ба гоомой бясалгалд самууралгүй их бага бодь мөрийн зэрэг, хоёр зэргийн хөтөлбөр тэргүүтэй судар тарнийн гол номуудаас ямар мэт заасан утгыг санаж бясалгахын ёс дагуу үйлд”¹⁵⁸ хэмээжээ.

Долоодугаарт, “Хийдийн ерөнхий дэглэм”-ийн хэсэгт хийд орон нь бурханы шашны оршин тогтнож, сүсэгтэн олонтой харьцах чухал газар билээ. Тиймээс хийд орон байгуулах нь чухал үйл хэрэг бөгөөд хийдэд урьдын мэргэд ихэс дээдсийн бүтээл туурвилын чухлыг хураангуйлан унших хэрэгтэй. Мөн хурал номын ая дан, хөгжмийн зэмсэг, тахил балин зэргийг жигд байлгах нь зохистой.

Шашны суурь нь винай учраас хуврагууд винайн гол гарын авлагыг нягт нямбай судлах, винайн зан үйлүүдийг зүй зохистойгоор үйлдэх нь чухал.

Хийдийн албан тушаалтнууд ажил үүрэгтэй, хариуцлагатай хандах, ялангуяа няравууд өглөгийн эзний өглөг, зэд тэргүүтнийг хуврагуудад тэгш хүртээх гэх мэтэд хариуцлагатай хандах тухай дурджээ. Эдгээр заалтаас жишээ дурдвал, “хийдийн албан тушаалтнууд винайн явдал мөр ба гол номуудыг цээжлэх тэргүүтэй сонсох, санах, бясалгахын үйлэнд нэгэн үзүүрээр шамдаж эрдэмтдийг урамшуулан магтах ба ахмад лам, өвдөн шаналсан хуврагуудыг үргэлж энхрийлэн асарч эм тариа, асаргаа сувилал, хоол хувцас тэргүүтнийг хийдийн удирдлагаас адил тэгш анхааран харж хуваарилагтун”¹⁵⁹ хэмээжээ.

Наймдугаарт, “Нийгмийн сайн сайхан хийгээд албан тушаалтны зүйл”-д бусдын тусын тулд хийд орны зүгээс нийгэмд хандсан үйл ажиллагааг зохион

¹⁵⁷ Далай лам Данзанжамц. “Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой”. УБ., 1992, 42 дахь тал

¹⁵⁸ Мөн тэнд 43 дахь тал

¹⁵⁹ Мөн тэнд 45 дахь тал

байгуулах, өөр өөрсдийн мэдлэг боловсролдоо таарах хэмжээний нийгэмд тустай үйлийг хийхийг хичээ гэжээ.

Мөн хийдийн албан тушаалтнууд хамба, унзад гэх зэрэг номын хэргэмтнүүд нь өөрсдийн сонгогдсон ажилдаа мэргэжсэн, хариуцлагатай байхыг дурджээ. Жишээ нь, "Орон хийдийн хамба лам нь хуврагуудын авал орхил, ялангуяа дотоод жаяг дүрмийг эрхлэн удирдагч мөн тул дээдийн ном винайн ёсыг сахисан, сонсох, санах бүтээхийн эрдмээр баялаг нэгэн байх хэрэгтэй. Унзад тэргүүтэй бусад номын хэргэмтнүүд өөр өөрсдийн оногдсон ажилдаа мэргэжсэн бөгөөд хариуцлагатай, аж ахуйн эрхлэгч нар ч мэдлэг боловсролтой, хашир шударга, ил далд башир хуурмаггүй байх хэрэгтэй"¹⁶⁰ хэмээн албан тушаалтнуудын хариуцлагын тухай товч оруулжээ.

Жаягийн ерөнхий бүтцийг дээр өгүүлсэнчлэн гаргаж болох ч Монголын бурханы шашны сүм хийдийн дотоод дүрэм журмыг тогтоосон жаягийн уламжлалт онцлогийг гаргахын тулд гарт олдсон нэгэн жаяг болох Ламын гэгээний анхдугаар дүр Лувсанданзанжанцаны өөрийн үүсгэн байгуулсан хийддээ зориулан туурвисан "Гандандашгэмпил их номын хийдийн хуварагуудын авч гээхийг ёсчлон үйлдэх цааз оршвой" хэмээх жаягийн тухай товчхон дурдъя.

Ламын гэгээний анхдугаар дүр нь монголд бурханы шашныг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан хүмүүсийн нэгэн бөгөөд тэрээр Төвдөд буддын мэдлэг ухааныг эзэмшээд нутагтаа эргэн ирснийхээ дараа нэгэн хийдийг байгуулсан түүхтэй. Энэ тухай олон эрдэмтдийн зохиол бүтээлд дурдагдсан байдаг. Тухайлбал Доктор, профессор Л. Хүрэлбаатар: "Тэрбээр Төвдийн Лхас, Дашлхүмбийн газраа зургаа долоон жил суугаад 24 сүүдэртэйдээ (1662) Халхын газраа эргэн морилж, орон хүрээг үүсгэн, Төвд Дашлхүмбийн дэгээр хуврагийн аймаг, дацан сургуулийг байгуулсан бөгөөд Бөөрөлжүүтийн газар шинэ хийд Гандандашгэмпэллин хэмээхийг цүглэж, гурван дацанг үүсгэж..."¹⁶¹ хэмээсэн байна.

Тиймээс ламын гэгээний анхдугаар Лувсанданзанжанцан нь өөрийн анх байгуулсан хүрээ хийд болох Гандандашгэмпэллин хийдийн дотоод үйл ажиллагаанд зориулж жаяг бичиг туурвижээ. Энэхүү жаяг нь Ламын гэгээний сүмбумын "ха" ботид багтах бөгөөд 4 хуудас зохиол байгаа.

Энэ зохиол нь мөргөлийн үг, лам хуврагууд тухайн хийдэд шавьлан суухдаа нэн тэргүүнд судлах зүйлс, хийхийг хориглосон үйлүүд, манз цавны үеийн зан үйл, төгсгөлийн үг гэх хэсгүүдээс бүрдэж байна. Энэхүү жаягийг гүрэмийн дацангийн үйл ажиллагаанд зориулан туурвисан гэдэг нь жаягийн хэсгээс харагддаг. Тухайлбал жаягт "Их гүрэм заслыг тавихад дара эхийг нэг удаа өнгөрөөхөд хүрвээс долоон удаа мөргүүл, долоон удаа өнгөрөөвөөс хорин

¹⁶⁰ Далай лам Данзанжамц. "Монгол орны хүрээ хийдүүдийн жаяг цааз оршвой". УБ., 1992, 37 дахь тал

¹⁶¹ Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1704). Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 1999, 15 дахь тал

байнга манж өргүүлэх сэлт хийгээд гурван зуу мөргүүлж, хоёр зуун зул өргүүлж, таван лан мөнгийг байнга жасад тушаа”¹⁶⁹ гэх мэт бусад олон заалтуудаас харагдаж байна.

Бас нэг гол ялгарах зан үйл нь манз цавны үед үйлдэх зан үйлийн талаар авч үзсэнд оршино. Жишээ нь, “Цайны үеэр эхлээд лавай үлээхэд гарч ирэн үүдний дэргэд Мэгзэм тэргүүтнийг айлдаж, гуравдахь удаагаа лавай үлээхэд дотор залраад хөгшин залуугийн эрэмбээр суудалдаа эндүүрэлгүй сууж, гэсгүй бээр эхлээд хүж эргүүлж утлага хүжийг уугиулж үйлдэнэ. Түүний дараа цайны үед хоёр дахь удаагаа хүж эргүүлэх лугаа цайг бэлдэнэ. Гэсгүй бээр цайгаа соёрхон өчихөд цайг таалаад эхлээд хурал унших ба өглөгийн эзэн ирэх аваас өглөгийн эзэн хийгээд байхгүй боловоос цайны дараа гуравдахь удаагаа хүж эргүүлнэ. Түүний дараа цөөнхийн цайны үед дөрөв дэх удаагаа хүжийг үйлдэж бага зэрэг цайг өчиж тэгш агуулж ерөөл байваас өргөж, жич бас манз байваас яруу сонсож хуралд үг өчих хэрэг байваас өчөөд лам бээр ерөөл үйлдмүй” хэмээн тухайн хийдийн манз хүртэхдээ үйлдэх зан үйлийн хэсгийг тодорхойлон заасан нь дэг журмыг тогтоох үндэс юм. Ийнхүү жаягуудын нийтлэг болоод ялгаатай талыг нарийвчлан харуулж болох ч энэ удаад жаяг бичгийг сүм хийдийн эрхзүйн хэм хэмжээг тодорхойлогч гэдэг талаас нь авч үзэх нь гол зорилго билээ. Тиймээс энэ эрхзүйн чиг үүрэг болоод хэм хэмжээний агуулга шинж нь жаяг бичигт хэрхэн тусгалаа олсон талаар авч үзье.

Хэм хэмжээг “ хэм хэмжээ гэдэг ойлголт нь горим журам гэсэн утгатай юм. Нийгмийн хэм хэмжээнүүд нь нийгмийн харилцааг зохицуулахад шийдвэрлэх нөлөө үзүүлдэг ”¹⁷⁰ хэмээн тодорхойлсноос үзвэл жаяг нь сүм хийдийн лам хуврагын үйл ажиллагааны дүрэм журмыг тогтоосон бичмэл хэм хэмжээ гэж үзэж болох юм. Тиймээс жаяг бичиг нь эрхзүйн актын онцлогыг агуулж байгаа учраас сүм хийдийн эрхзүйн хэм хэмжээг тодорхойлогч гол актын нэг хэлбэр гэдгийн нотлон харуулж байна.

Тэгэхээр шашны эрхзүйн баримт бичгийн нэг хэлбэр нь жаяг бичиг байж болох юм. Эрхзүйн баримт бичгийн гол шинжүүдэд нийгмийн харилцаанд оролцогчдын зан үйлийн хэр хэмжээг хуульчлан тодорхойлсон буюу горимлосон шинжтэй, бичигдмэл албан ёсны бөгөөд хууль зүйн шинжийг илэрхийлсэн хэм хэмжээний агуулгатай, зохицуулалтын харьцангуй нийтлэг журам тогтоосон шинжтэй, эрхзүйн хэм хэмжээний баримт бичиг бүтцийн хувьд бүлэг, хэсэг, зүйл анги болон үндэслэл тогтоох хэсэг зэрэг эрэмбэ дараалал бүхий тодорхой заалтыг өөртөө агуулдгаар онцлог шинжтэй гэх зэрэг өөр олон шинж чанарууд байгаагаас эдгээр нь жаягийн бүтэц агуулгатай холбогдох боломжтой бөгөөд жаягт эрхзүйн баримт бичгийн шинжийн агуулга байна гэж үзэж болох юм.

Нөгөөтэйгүүр жаяг бичгийн уламжлалт хийгээд орчин үеийн аль ч хэлбэрт эрхзүйн гол ойлголт болох үүрэг хүлээлгэж, хариуцлага тооцдог зохицуулалтын

¹⁶⁹ Ламын гэгээн Лувсанданзанжанцан. Гандандашгэмпил их номын хийдийн хуврагуудын авч гээхийг ёсчлон үйлдэх цааз оршвой. Төвдөөр.

¹⁷⁰ Д. Баярсайхан. Эрхзүйн онол. УБ., 2005, 34 дэх тал

чиг үүргийг илэрхийлсэн лам хуврагуудын биелүүлэх үүрэг, баримтлах ёстой зарчим, түүнийг зөрчихөд шийтгэх хэлбэр зэргийг маш тодорхой авч үзсэн нь жаяг бичгүүдийг сүм хийдийн эрхзүйн баримт бичиг болохын бас нэгэн нотолгоо юм.

SUMMARY

The activities the Buddhist monks do are managed by the procedures and rules. The rules in the monasteries are the type of legal documents. At the beginning of the XVII-XVIII centuries, most of the Buddhist monks created the rules and procedures to be followed in the monasteries and temples in Tibetan language.

НОМ ЗҮЙ

1. Д. Баярсайхан. Эрхзүйн онол. УБ., 2005
2. Валпола Рахула. Будда чухам юу сургасан нь. УБ., 2007
3. XIV Далай лам. Төвдийн бүддийн ертөнц.
4. Ламын гэгээн Лувсанданзанжанцан. Гандандашгэмпил их номын хийдийн хуврагуудын авч гээхийг ёсчлон үйлдэх цааз оршвой. Модон бар.
5. Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1704). Эрдэм шинжилгээний бичиг. УБ., 1999
6. Пүрэвжав. С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978